



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2023/175/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Чойбалсан хот 2023 он	Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
	Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn
	Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Ари файнэнс аудит" ХХК Утас: 99088151 Цахим хаяг: arifin.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2023.02.24 № 202
танай _____ -ны № _____ -т

БАЯНДУН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ш.БАТЖАВ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяндун сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баяндун сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсрол шинжлэх ухааны яам 2022 оноос эхлэн төсвийн шинэчлэлийн хүрээнд төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор чанар, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнээр Улсын төсвийн хуваарь болон санхүүжилт БШУЯ, БЕГ-аас шууд хуваарилагдан хянагдаж ирдэг болсон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, суралцагчийн сурлагын чанарыг хараат бусаар үнэлэх, багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн, бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах зорилгоор энэ хичээлийн жилээс Боловсролын нэгдсэн мэдээллийн систем /esis/-ийн бүх үйл ажиллагаа тухайлбал: багш ажилтан, ажилчдын өөрчлөгдсөн цалин, бусад нэмэгдлүүд,

011020174

холбоо барих мэдээлэл, байршил, үндэсний болон орон нутгийн сургалтад хамрагдсан байдал, сурагчдын үнэлгээ, харьяалал, байршил, асран хамгаалагчийн мэдээлэл, багш нарын цахим журналын шинэчлэл, санхүү, хөрөнгийн мэдээлэл, статистик мэдээлэл зэрэг үйлдлүүд шинэчлэгдэн өөрчлөгдсөнтэй холбогдуулан зохих журам тушаал, шийдвэрийн дагуу цаг хугацаанд нь мэдээллийг оруулснаар мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаж байна. Энэ нь БШУЯ болон бусад яамдуудын мэдээллийн эх үүсвэр болон ашиглагдаж байгаагаараа онцлог байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	131,900,763.09	272,544,878.74
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		132,805,235.65
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө		132,805,235.65
31210	Төгрөг		132,805,235.65
31211	Төрийн сангийн харилцах		132,805,235.65
312112	Улсын төсвийн харилцах		132,805,235.65
35	БАРАА МАТЕРИАЛ	131,900,763.09	139,739,643.09
35100	Түүхий эд материал		4,695,700.00
35110	Тусгай зориулалттай материал		4,695,700.00
35400	Хангамжийн материал	131,900,763.09	135,043,943.09
35410	Бичиг хэргийн материал	47,769,496.96	47,769,496.96
35420	Аж ахуйн материал	78,581,266.13	78,581,266.13
35430	Сэлбэг хэрэгсэл		196,000.00
35460	Хүнсний материал		501,180.00
35470	Бусад хангамжийн материал	5,550,000.00	7,996,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	2,090,765,221.67	2,002,244,104.89
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,090,765,221.67	2,002,244,104.89
39200	Биет хөрөнгө	2,035,428,950.79	1,946,907,834.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,937,928,354.77	1,947,928,354.77
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	-222,383,698.45	-379,512,331.57
39203	Авто-тээврийн хэрэгсэл	75,000,000.00	75,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	-50,000,000.16	-62,500,000.20
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	315,674,972.50	406,386,867.50
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	-188,121,214.59	-200,649,828.18
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	73,258,333.00	81,892,738.98
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	-28,647,123.08	-33,139,876.54
39209	Зам, гүүрийн байгууламж	6,514,115.16	6,514,115.16
39210	Хуримтлагдсан элэгдэл - Зам гүүр	-1,830,440.16	-2,696,406.36
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	31,950,650.00	32,076,150.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	106,519,654.90	105,816,034.90
39215	Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө	-41,572,182.41	-52,614,889.76
39217	Номын фонд	21,137,529.31	22,406,905.31
39300	Биет бус хөрөнгө	55,336,270.88	55,336,270.88
39303	Бусад биет бус хөрөнгө	55,336,270.88	55,336,270.88
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	2,222,665,984.76	2,274,788,983.63
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	2,222,665,984.76	2,274,788,983.63
51	Засгийн газрын хувь оролцоо	2,222,665,984.76	2,274,788,983.63
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	434,020,522.80	434,020,522.80

**Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

511001	Засгийн газрын оруулсан капитал засгийн газрын сан	434,020,522.80	434,020,522.80
51200	Хуримтлагдсан үр дүн	1,160,752,962.15	1,212,875,961.02
51210	Өмнөх үеийн үр дүн	1,330,639,316.73	-1,061,913,022.61
51220	Тайлант үеийн үр дүн	-169,886,354.58	2,274,788,983.63
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	627,892,499.81	627,892,499.81
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	2,222,665,984.76	2,274,788,983.63

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,197,126,373.88	3,588,874,540.76
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,260,617,973.88	2,315,248,640.76
120	Нийтлэг татварын бус орлого	1,260,617,973.88	2,315,248,640.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,260,617,973.88	2,315,248,640.76
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,648,100.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,260,617,973.88	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө		2,174,934,077.67
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа материал		138,666,463.09
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	936,508,400.00	1,273,625,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	888,440,100.00	1,158,220,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	888,440,100.00	1,158,220,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	800,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	800,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	47,268,300.00	115,405,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	47,268,300.00	115,405,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,028,923,498.39	1,303,310,780.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,028,923,498.39	1,303,310,780.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	925,915,234.44	1,231,153,481.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	656,154,925.63	758,344,283.55
210101	Үндсэн цалин	455,405,404.46	541,881,982.04
210102	Нэмэгдэл	160,358,801.53	178,183,019.12
210104	Урамшуулал	40,390,719.64	38,279,282.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,530,780.57	95,038,287.80
210201	Тэтгэврийн даатгал	55,673,445.76	65,435,351.26
210202	Тэтгэмжийн даатгал	6,903,656.88	7,884,644.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,716,400.00	6,022,676.83
210204	Ажилгүйдлийн даатгал	1,429,000.00	1,438,423.51
210205	Эрүүл мэндийн даатгал	12,808,277.93	14,257,192.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,082,955.30	52,906,464.65
210301	Гэрэл, цахилгаан	11,711,675.30	13,338,160.33
210302	Түлш, халаалт	31,407,280.00	37,568,304.32
210303	Цэвэр, бохир ус	964,000.00	2,000,000.00

**Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2104	Хангамж, бараа материалын зардал	25,169,129.12	
210401	Бичиг хэрэг	5,310,504.08	
210402	Тээвэр, шатахуун	2,670,000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,937,100.00	
210404	Ном, хэвлэл	138,100.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	950,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,163,425.04	
2105	Нормативт зардал	22,776,650.00	65,770,126.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,787,800.00	
210502	Хоол, хүнс	18,988,850.00	65,770,126.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	148,750.00	3,285,100.00
210604	Урсгал засвар	148,750.00	3,285,100.00
2107	Томилолт, зочны зардал	600,000.00	
210702	Дотоод албан томилолт	600,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,429,750.00	10,222,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,249,750.00	1,648,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	8,573,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,022,293.82	245,587,219.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,244,584.00	26,581,503.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,039,957.00	8,856,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	84,737,752.82	210,149,516.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	103,008,263.95	72,157,299.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,989,422.00	66,846,860.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,989,422.00	55,692,960.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	11,153,900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	85,018,841.95	5,310,439.35
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	85,018,841.95	5,310,439.35
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1,168,202,875.49</u>	<u>2,285,563,760.07</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	455,188.12	10,774,776.44
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	455,188.12	10,774,776.44
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(455,188.12)	(10,774,776.44)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>1,167,747,687.37</u>	<u>2,274,788,983.63</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>936,508,400.00</u>	<u>1,275,274,000.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,648,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	1,648,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1,648,100.00

**Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,648,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	936,508,400.00	1,273,625,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	888,440,100.00	1,158,220,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	888,440,100.00	1,158,220,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	800,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	800,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	47,268,300.00	115,405,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	47,268,300.00	115,405,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	936,508,400.00	1,094,234,444.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	936,508,400.00	1,094,234,444.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	832,906,898.05	1,022,077,145.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	656,154,925.63	758,344,283.55
210101	Үндсэн цалин	455,405,404.46	541,881,982.04
210102	Нэмэгдэл	160,358,801.53	178,183,019.12
210104	Урамшуулал	40,390,719.64	38,279,282.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,406,756.12	95,038,287.80
210201	Тэтгэврийн даатгал	55,549,421.31	65,435,351.26
210202	Тэтгэмжийн даатгал	6,903,656.88	7,884,644.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,716,400.00	6,022,676.83
210204	Ажилгүйдлийн даатгал	1,429,000.00	1,438,423.51
210205	Эрүүл мэндийн даатгал	12,808,277.93	14,257,192.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,118,955.30	52,906,464.65
210301	Гэрэл, цахилгаан	11,711,675.30	13,338,160.33
210302	Түлш, халаалт	31,407,280.00	37,568,304.32
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	2,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,986,570.00	
210401	Бичиг хэрэг	1,662,670.00	
210402	Тээвэр, шатахуун	2,670,000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,937,100.00	
210404	Ном, хэвлэл	570,900.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	950,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,195,900.00	
2105	Нормативт зардал	22,776,650.00	66,271,306.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,787,800.00	
210502	Хоол, хүнс	18,988,850.00	66,271,306.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	148,750.00	3,285,100.00
210604	Урсгал засвар	148,750.00	3,285,100.00
2107	Томилолт, зочны зардал	600,000.00	
210702	Дотоод албан томилолт	600,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,429,750.00	10,222,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,249,750.00	1,648,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	

**Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	8,573,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,284,541.00	36,009,703.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,244,584.00	23,153,703.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,039,957.00	12,856,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	103,601,501.95	72,157,299.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,582,660.00	66,846,860.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,582,660.00	55,692,960.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	11,153,900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	85,018,841.95	5,310,439.35
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	85,018,841.95	5,310,439.35
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	≡	<u>181,039,555.65</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	48,234,320.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	48,234,320.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	48,234,320.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		48,234,320.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	≡	<u>(48,234,320.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	132,805,235.65
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	132,805,235.65

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	434,020,522.80	627,892,499.81	-1,061,913,022.61	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	434,020,522.80	627,892,499.81	-1,061,913,022.61	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	2,274,788,983.63	2,274,788,983.63
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	434,020,522.80	627,892,499.81	1,212,875,961.02	2,274,788,983.63

2.5 Аудит хийсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,276,302,000.00	1,137,158,325.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,276,302,000.00	1,137,158,325.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,202,960,200.00	1,070,311,465.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	866,547,869.00	758,344,283.55
210101	Үндсэн цалин	653,022,605.00	541,881,982.04

**Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210102	Нэмэгдэл	188,591,182.00	178,183,019.12
210104	Урамшуулал	24,934,082.00	38,279,282.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	108,405,327.00	95,038,287.80
210201	Тэтгэврийн даатгал	73,720,089.69	65,435,351.26
210202	Тэтгэмжийн даатгал	8,673,216.40	7,884,644.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,938,393.12	6,022,676.83
210204	Ажилгүйдлийн даатгал	1,734,175.25	1,438,423.51
210205	Эрүүл мэндийн даатгал	17,339,452.54	14,257,192.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,906,464.65	52,906,464.65
210301	Гэрэл, цахилгаан	18,648,599.68	13,338,160.33
210302	Түлш, халаалт	37,568,304.32	37,568,304.32
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	2,000,000.00
2105	Нормативт зардал	69,806,800.00	66,271,306.00
210502	Хоол, хүнс	69,806,800.00	66,271,306.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,595,539.35	3,285,100.00
210604	Урсгал засвар	8,595,539.35	3,285,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,256,000.00	10,222,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,676,100.00	1,648,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,579,900.00	8,573,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	85,442,200.00	84,244,023.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	72,572,400.00	71,388,023.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,869,800.00	12,856,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	73,341,800.00	66,846,860.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	73,341,800.00	66,846,860.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	62,187,900.00	55,692,960.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,153,900.00	11,153,900.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,276,302,000.00	1,269,963,560.65
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,158,220,200.00	1,158,220,200.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,158,220,200.00	1,158,220,200.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,676,100.00	1,648,100.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,676,100.00	1,648,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	115,405,700.00	110,095,260.65
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	115,405,700.00	110,095,260.65
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	132,805,235.65

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн зөрчилд 3 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн.

3.1 Албан шаардлага

1. Хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын даргын тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулах комиссыг томилж хөрөнгийн тооллогыг гүйцэтгүүлсэн боловч тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2. "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1. "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" заалт; 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

2. Дансны үлдэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байр ашиглалттай холбоотой зардлын бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай байгуулсан гэрээг аудитад ирүүлээгүй, бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай тооцоо хийж, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6. "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

3. Худалдан авалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2. "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ", 17 дугаар зүйлийн 17.1. "Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу зарлан мэдээлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана", 30.4. "Бүх тендерээс татгалзсан тохиолдолд захиалагч дараах шийдвэрийн аль нэгийг гаргана", 30.4.1 "тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах", 30.4.2 "энэ хуулийн 30.1.3, 30.1.4-т заасан нөхцөл үүссэн бөгөөд тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь зөвхөн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, цар хүрээтэй холбоотой бол тэдгээртэй холбогдолтой өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулж,

хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах”, 30.4.3 “энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах”, 34 дүгээр зүйлийн 34.3 “Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлогын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Түрээсийн номноос орсон орлогыг аккурэл сууриар бүртгээгүйгээс орлогыг дутуу илэрхийлсэн байх, нотлох баримтгүй, тайлан тооцоо гаргаж ажиллаагүй зэрэг зөрчил гаргаж бүртгэлээр тавих хяналтыг сулруулсан байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалттай нийцээгүй, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Түрээсийн номноос орсон орлогыг аккурэл сууриар бүртгэн бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах

2. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сурагчдын хоолны санхүүжилтийг esis.edu цахим системд сурагчдын өдөр тутмын ирцийг хөтлөн няравын тайланд бүртгэж тооцоо хийдэггүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно" гэж 5 дугаар зүйлийн 5.1.1 Үнэн зөв байх гэсэн заалтуудтай нийцээгүй, иж бүрэн, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтгүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын даргын тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулах комиссыг томилж хөрөнгийн тооллогыг гүйцэтгүүлсэн боловч тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.	1	-			1			
Байр ашиглалттай холбоотой зардлын бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай байгуулсан гэрээг аудитад ирүүлээгүй, бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай тооцоо хийж, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	-		-	1			
Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан.	1	-		-	1			
Түрээсийн номноос орсон орлогыг аккурэл сууриар бүртгээгүйгээс орлогыг дутуу илэрхийлсэн байх, нотлох баримтгүй, тайлан тооцоо гаргаж ажиллаагүй зэрэг зөрчил гаргаж бүртгэлээр тавих хяналтыг сулруулсан байна.	1	-					1	
Сурагчдын хоолны санхүүжилтийг esis.edu цахим системд сурагчдын өдөр тутмын ирцийг хөтлөн няравын тайланд бүртгэж тооцоо хийдэггүй	1	-					1	
Дүн	5	-	-	-	3	-	2	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд гэрэл цахилгаан, дулааны зардалд Тайлант хугацаанд 31,977.5 мянган төгрөг зарцуулсан ба өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 7.2%-иар өссөн байна.	1	2,157.0					1	2,157.0
Нийт дүн	1	2,157.0					1	2,157.0



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 86/01 ДОН-2023/175/НА-СТА-ТШЗ

Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2. "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ", 17 дугаар зүйлийн 17.1. "Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу зарлан мэдээлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана", 30.4. "Бүх тендерээс татгалзсан тохиолдолд захиалагч дараах шийдвэрийн аль нэгийг гаргана", 30.4.1 "тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах", 30.4.2 "энэ хуулийн 30.1.3, 30.1.4-т заасан нөхцөл үүссэн бөгөөд тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь зөвхөн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, цар хүрээтэй холбоотой бол тэдгээртэй холбогдолтой өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулж, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах", 30.4.3 "энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах", 34 дүгээр зүйлийн 34.3 "Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн
ШААРДАХ нь:

011040453

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, алдаа зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Ш.Батжав, нягтлан бодогч Б.Оюунгэрэл нарт даалгав.


АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН АУДИТЫН МЕНЕЖЕР



И.СЭМЖИДМАА

АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Д.АРИУНАА



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 82/02 ДАА/2023/175/НА-СТА-ТШЗ Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын даргын тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулах комиссыг томилж хөрөнгийн тооллогыг гүйцэтгүүлсэн боловч тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2. "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1. "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" заалт; 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.2 "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эд хөрөнгийн тооллого хийгдсэний дараа хөрөнгийн тооцоог бодож, тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулсан байх, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Ш.Батжав, нягтлан бодогч Б.Оюунгэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН АУДИТЫН МЕНЕЖЕР
АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



И.СЭМЖИДМАА

Д.АРИУНАА

011040459



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 38/03 ДОА/2023/175/НА-СТА-ТШЗ Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байр ашиглалттай холбоотой зардлын бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай байгуулсан гэрээг аудитад ирүүлээгүй, бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай тооцоо хийж, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6. “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.7 “авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай тооцоо хийж, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Ш.Батжав, нягтлан бодогч Б.Оюунгэрэл нарт даалгав.


АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН АУДИТЫН МЕНЕЖЕР

И.СЭМЖИДМАА

АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Д.АРИУНАА



011040461